**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Орхон аймгийн Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн**
**2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код: ОРА-2025/010/НА-СТА-ТШЗ**

---


Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakh@audit.gov.mn

Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2025.02.21 № 32
танай ____ -ны № ____ -т

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.НЯМААНЯМБУУ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 128 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөхөөр сурГуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг 7 дугаар хавсралтаар баталж, албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 10,904.3 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй болсонтой холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Боловсролын Ерөнхий газраас 202 оны 12 дугаар сарын 21-ны 01/6148 дугаар албан тоотоор Аймгийн Засаг даргын тамгын газарт чиглэл хүргүүлсний дагуу ерөнхий сургуулиудад гал тогооны түрээслэгч аж ахуйн нэгжийн гэрээг дуусгавар болгож, сургуулийн хэмжээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээг үзүүлэх ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 31,738.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хүнсний түүхий эд материал, тоног төхөөрөмж, ажиллагсдын эрүүл ахуйн хувцас, аж ахуйн материалын зардалд нийт 29,388.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд үнэлээгүй байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 370 хүүхдээр тооцсон боловч 478 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **215,926,321.79** | **248,497,640.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 100,590,309.48 | 111,494,621.39 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 100,590,309.48 | 111,494,621.39 |
| **3121** | **Төгрөг** | 100,590,309.48 | 111,494,621.39 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 100,590,309.48 | 111,494,621.39 |
| **33** | **АВЛАГА** | 890,542.28 | 890,542.28 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 890,542.28 | 890,542.28 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **114,445,470.03** | **135,476,976.63** |
| **351** | **Түүхий эд материал** | **113,095,920.03** | **127,767,536.63** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 112,714,220.03 | 127,767,536.63 |
| 35130 | Эм боох материал | 381,700.00 | 283,100.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 540,050.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **1,349,550.00** | **7,169,390.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 591,140.00 | 958,240.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 758,410.00 | 1,164,350.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 4,907,800.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 84,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 55,000.00 |
| 36 | Нөөцийн бараа | | 449,500.00 |
| 366 | Бусад нөөц | | 449,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,571,013,304.58** | **2,586,616,821.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,571,013,304.58** | **2,586,616,821.97** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,430,153,304.76** | **1,482,845,655.32** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,374,322,064.73 | 1,379,357,564.73 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (302,336,299.31) | (335,025,808.63) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 338,019,722.40 | 442,121,388.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (135,903,715.00) | (160,742,896.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 162,175,039.05 | 164,362,931.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (55,151,970.68) | (60,062,181.19) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 95,561,938.77 | 103,960,998.77 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (46,533,475.20) | (51,126,342.72) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **1,140,859,999.82** | **1,103,771,166.65** |
| 39301 | Програм хангамж | 6,550,000.00 | 8,090,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,595,000.18) | (3,327,000.01) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,136,905,000.00 | 1,136,905,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (37,896,833.34) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,786,939,626.37** | **2,834,928,462.27** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,786,939,626.37** | **2,834,928,462.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,786,939,626.37 | 2,834,928,462.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,915,700,397.17 | 1,915,700,397.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,915,700,397.17 | 1,915,700,397.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 68,492,340.36 | 116,481,176.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 68,492,340.36 | 68,492,340.36 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 47,988,835.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 802,746,888.84 | 802,746,888.84 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,786,939,626.37** | **2,834,928,462.27** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,478,378,096.46** | **1,961,671,710.24** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **175,710,596.46** | **245,103,010.24** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **175,710,596.46** | **245,103,010.24** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,026,705.00 | 135,654,364.64 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,452,400.00 | 2,041,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,574,305.00 | 133,612,864.64 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 139,323,834.00 | 106,245,419.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал | 24,360,057.46 | 3,203,226.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,302,667,500.00** | **1,716,568,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,219,817,000.00** | **1,596,176,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,219,817,000.00 | 1,596,176,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **82,850,500.00** | **120,391,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,850,500.00 | 120,391,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,350,856,411.26** | **1,913,682,874.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,350,856,411.26** | **1,913,682,874.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,287,792,660.68** | **1,841,461,878.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **918,727,661.12** | **1,322,005,467.90** |
| 210101 | Үндсэн цалин | 650,025,119.09 | 840,810,397.84 |
| 210102 | Нэмэгдэл | 232,399,178.73 | 425,155,189.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,590,800.00 | 8,189,869.09 |
| 210104 | Урамшуулал | 34,712,563.30 | 47,850,011.46 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **117,916,641.19** | **166,879,001.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,004,069.95 | 114,317,693.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,494,608.12 | 13,119,734.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,366,887.30 | 6,639,168.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,811,549.48 | 6,580,851.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,239,526.34 | 26,221,552.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **53,188,249.42** | **54,925,965.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,460,109.86 | 19,889,335.48 |
| 210302 | Түлш, халаалт | 29,843,076.95 | 27,749,400.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,885,062.61 | 7,287,229.31 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **33,217,010.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 33,217,010.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,750,500.00** | **34,980,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 11,750,500.00 | 34,980,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,392,400.00** | **24,533,603.42** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,452,400.00 | 2,038,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,940,000.00 | 22,495,203.42 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **166,779,508.95** | **204,920,130.61** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,127,750.00 | 85,619,581.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,473,600.00 | 13,563,640.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 127,178,158.95 | 105,550,909.61 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,063,750.58** | **72,220,995.72** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **50,652,000.00** | **54,053,661.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 50,652,000.00 | 54,053,661.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **12,411,750.58** | **18,167,334.72** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,411,750.58 | 18,167,334.72 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **127,521,685.20** | **47,988,835.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,314,694,205.00** | **1,852,223,064.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,026,705.00** | **135,654,364.64** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,026,705.00 | 135,654,364.64 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12,026,705.00 | 135,654,364.64 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,452,400.00 | 2,041,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,574,305.00 | 133,612,864.64 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,302,667,500.00** | **1,716,568,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,219,817,000.00 | 1,596,176,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,219,817,000.00 | 1,596,176,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 82,850,500.00 | 120,391,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,850,500.00 | 120,391,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,213,593,302.31** | **1,826,300,052.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,213,593,302.31** | **1,826,300,052.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,150,529,551.73** | **1,754,079,057.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 918,727,661.12 | 1,322,005,467.90 |
| 210101 | Үндсэн цалин | 651,681,025.37 | 840,810,397.84 |
| 210102 | Нэмэгдэл | 230,782,874.40 | 425,155,189.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,590,800.00 | 8,189,869.09 |
| 210104 | Урамшуулал | 34,672,961.35 | 47,850,011.46 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,916,641.19 | 166,879,001.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,004,069.95 | 114,317,693.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,494,608.12 | 13,119,734.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,366,887.30 | 6,639,168.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,811,549.48 | 6,580,851.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,239,526.34 | 26,221,552.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,188,249.42 | 54,925,965.28 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,460,109.86 | 19,889,335.48 |
| 210302 | Түлш, халаалт | 29,843,076.95 | 27,749,400.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,885,062.61 | 7,287,229.31 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 33,217,010.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 33,217,010.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,750,500.00 | 47,298,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,750,500.00 | 47,298,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,807,400.00 | 26,106,603.42 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,452,400.00 | 2,038,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,355,000.00 | 24,068,203.42 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,139,100.00 | 103,646,509.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,655,500.00 | 89,641,216.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,483,600.00 | 14,005,293.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,063,750.58** | **72,220,995.72** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,652,000.00 | 54,053,661.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 50,652,000.00 | 54,053,661.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,411,750.58 | 18,167,334.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,411,750.58 | 18,167,334.72 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **101,100,902.69** | **25,923,011.91** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **38,021,500.00** | **15,018,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **38,021,500.00** | **15,018,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 38,021,500.00 | 15,018,700.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 15,018,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(38,021,500.00)** | **(15,018,700.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 63,079,402.69 | 10,904,311.91 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 100,590,309.48 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 100,590,309.48 | 111,494,621.39 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,915,700,397.17** | **802,746,888.84** | **68,492,340.36** | **2,786,939,626.37** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,915,700,397.17** | **802,746,888.84** | **68,492,340.36** | **2,786,939,626.37** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 47,998,835.90 | 47,998,835.90 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,915,700,397.17** | **802,746,888.84** | **116,481,176.26** | **2,834,928,462.27** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,852,223,065.00** | **1,823,151,418.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,852,223,065.00** | **1,808,132,718.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,791,702,065.00** | **1,754,079,057.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,325,285,400.00** | **1,322,005,467.90** |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 917,791,500.00 | 840,810,397.84 |
| 210102 | Нэмэгдэл | 406,029,500.00 | 425,155,189.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 8,189,869.09 |
| 210104 | Урамшуулал | 1,464,400.00 | 47,850,011.46 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **165,660,700.00** | **166,879,001.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 112,649,300.00 | 114,317,693.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,252,900.00 | 13,119,734.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,626,400.00 | 6,639,168.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,626,400.00 | 6,580,851.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,505,700.00 | 26,221,552.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **72,391,800.00** | **54,925,965.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,100,000.00 | 19,889,335.48 |
| 210302 | Түлш, халаалт | 41,740,200.00 | 27,749,400.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,551,600.00 | 7,287,229.31 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **33,217,010.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 33,217,010.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **48,000,000.00** | **47,298,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 48,000,000.00 | 47,298,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,986,600.00** | **26,106,603.42** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,038,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,986,600.00 | 24,068,203.42 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **153,377,565.00** | **103,646,509.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,363,265.00 | 89,641,216.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,014,300.00 | 14,005,293.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **60,521,000.00** | **54,053,661.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **60,521,000.00** | **54,053,661.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 60,521,000.00 | 54,053,661.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **15,018,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **15,018,700.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 15,018,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,852,223,065.00** | **1,852,223,064.64** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,596,176,900.00** | **1,596,176,900.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,596,176,900.00 | 1,596,176,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **120,391,800.00** | **120,391,800.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 120,391,800.00 | 120,391,800.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **135,654,365.00** | **135,654,364.64** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,041,500.00 | 2,041,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 133,612,865.00 | 133,612,864.64 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **100,590,309.48** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **111,494,621.39** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 59,992.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 59,992.1 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

***Залруулсан алдаа:***

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд ажил олгогчоос төлөх НДШ-ийг 2,506.7 мянган төгрөгөөр, даатгуулагчаас суутгасан ндш-ийг 174.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, НДШ-ийг 84.8 мянган төгрөгөөр илүү төлж, хагас жилийн санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй, Нийгмийн даатгалын тайланд 1,521.4 мянган төгрөгийн цалин илүү тайлагнаж, ажил олгогчоос төлөх 190.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн.
- 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 11,158.5 мянган төгрөгийн авлага, 8,866.7 мянган төгрөгийн өглөг үүсгэж, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, тайлант онд хувь хүмүүст төлөх 6,734.2 мянган төгрөгийн өглөгийг байгууллагад төлөх дансны ангилалд тайлагнасан.
- Хүнсний материалын 12,645.8 мянган төгрөгийн материалыг бусад хангамжийн материалын дансанд, бичиг хэргийн материал 1,822.4 мянган төгрөгийн материалыг бэлэн бүтээгдэхүүн бараа материалын ангилалд, урсгал засварын 6,926.6 мянган төгрөгийн материалыг барилгын материалын дансны ангилал буруу бүртгэсэн
- Худалдаж авсан 4 нэр төрлийн 2,640.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансны ангилал буруу бүртгэсэн.
- Бараа үйлчилгээний бусад зардлаас леминатор машин 180.0 мянган төгрөгийн зардал гаргаж, шаардахаар зарлага гаргасан.
- Эргэлтийн хөрөнгийн шинжтэй 5 нэр төрлийн 4,540.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансны ангилалд бүртгэсэн зэрэг нийт 59,992.1 мянган төгрөгийн 6 зөрчилд завсрын аудитаар зөвлөмж хүргүүлж биелэлтийг хянахад жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулсан тул биелснээр тооцсон.

Аудитаар нийт 6,951.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 4,338.3 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,544.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,069.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

## 5.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,338.3 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт хүргүүлэв. Үүнд:

- Тайланд онд 2 албан хаагчид 543.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон.
- Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/238 А/340 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад заагаагүй шинжилгээнд албан хаагчдыг хамруулж, 3,100.0 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
- Сургуулийн захиралд Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалыг үндэслэн 694.8

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон нийт 4,338.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,544.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн сургуулийн захиралд 1,544.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.
- Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн 88,967.7 мянган төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Цалин хөлстэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлант онд дизайн технологийн эмэгтэй багшид эрэгтэй дизайн технологийн багшийн ажлыг хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргаж 1,069.2 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна. Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Батлагдсан орон тоонд мэргэжлийн албан хаагч ажиллуулах.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль | 6 | 59.9 | | | 6 | 59.9 | 6 | 59.9 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 6 | 59.9 | | | 6 | 59.9 | 6 | 59.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль | 5 | 6.9 | 3 | 4.3 | 2 | 1.5 | 1 | 1.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **5** | **6.9** | **3** | **4.3** | **2** | **1.5** | **1** | **1.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Орхон аймгийн Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 6 | **6.9** | **3** | **4.3** | **2** | **1.5** | **1** | **1.0** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **НИЙТ** | 1 | 1 | | | 1 | | | |